

**ТҮШИГ УУЛ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ**

2023.04.29

Дугаар 1

Дархан-Уул аймаг

ТАЙЛАН, ТӨСӨЛ БАТЛАХ ТУХАЙ

Компанийн тухай хуулийн 62.1.9 дэх хэсэг, 2023 оны 4 дугаар сарын 29 -ны өдрийн тооллогын комиссын 2-р тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Компанийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг баталсугай.

ХУРЛЫН ДАРГА



/ Ж.Батсайхан /

ТҮШИГ УУЛ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТООЛЛОГЫН КОМИССЫН ТОГТООЛ

2023.04.29

Дугаар 1

Дархан-Уул аймаг

Хувьцаа эзэмшигчдийн хурлын ирцийн тухай
болон хурлыг хүчин төгөлдөрт тооцох тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.3.1 дэх заалт 69 дүгээр зүйлийн 69.1 дэх хэсгийг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Хувьцаа эзэмшигчдийн энэ удаагийн хуралд 3437000 хувьцаа эзэмшдэг 4 хувьцаа эзэмшигчид биеэр оролцож байгаа болон саналын хуудсаар саналаа өгсөн нь нийт саналын эрх бүхий энгийн хувьцааны 79.1 хувь болж байгааг хуралд оролцогчид болон хурлын даргад мэдээлсүгэй.
2. Компанийн тухай хуулийн 69.1 дэх хэсгийг үндэслэн нийт саналын эрхтэй энгийн хувьцааны 79.1 хувийг эзэмшигчид хуралд оролцож байгааг үндэслэн компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлыг хүчин төгөлдөрт тооцсугай.

ТООЛЛОГЫН
КОМИССЫН ДАРГА  Б.Эрдэнэтуяа



**ТҮШИГ УУЛ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТООЛЛОГЫН КОМИССЫН ТОГТООЛ**

2023.04.29

Дугаар 2

Дархан-Уул аймаг

Санал хураах хуудсыг тоолсон дүнгийн тухай:

Компанийн тухай хуулийн 72 дугаар зүйл, санал хураах хуудсыг тоолсон дүнг үндэслэн ТОГТООХ НЬ:

1.Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцсэн асуудлуудаар санал хураасан дүн дараах байдалтай байгааг хуралд оролцогчдод мэдээлсүгэй:

1.1. Компанийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг батлах
Зөвшөөрсөн 3437000 ширхэг хувьцаа буюу 79.1 хувь, зөвшөөрөөгүй ширхэг хувьцаа буюу хувь

2. Санал хураасан асуудал тус бүрээр хувьцаа эзэмшигчдээс өгсөн зөвшөөрсөн санал нь Компанийн тухай хуулийн 63 дугаар зүйлд заасан хурлын шийдвэр хүчин төгөлдөр болох хувьд хүрсэн тул хурлын шийдвэрийг батлах тогтоолын төслийг хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулсугай.

ТООЛЛОГЫН
КОМИССЫН ДАРГА.....Б.Эрдэнэтуяа

